

ХУДАЛДАА ХӨГЖЛИЙН БАНК
ТУЗ-ИЙН ХАРААТ БУС ГИШҮҮНИЙ ТАЙЛАН
2025 оны эхний хагас жил

Төлөөлөн Удирдах Зөвлөл (ТУЗ)-ийн хараат бус гишүүн Ж.Дэлгэрсайхан

Миний бие тус банкны ТУЗ-ийн хараат бус гишүүн, Аудитын хорооны дарга, Эрсдэлийн удирдлагын хорооны гишүүнээр ажиллаж байна.

Монголбанкнаас баталсан “Банкны төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүнийг нэр дэвшүүлэх, томилох, чөлөөлөх журам”-ын 5.1-д заасны дагуу өөрийн ажлыг тайлагнаж байна.

2025 оны эхний хагас жилд ТУЗ-ийн, ТУЗ-н дэргэдэх хороодын хуралд оролцсон байдал:

Хүснэгт 1. Хуралд оролцсон байдал

д/д	Хурал, оролцсон ажлууд	Огноо	Оролцсон хэлбэр	Хэлэлцсэн асуудал
1	ТУЗ-н хурал	2025-01-17	Цахимаар	- Банкны Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх болон үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэхийг санхүүжүүлэхтэй тэмцэх үйл ажиллагааны тайлан (2024 оны 4 дүгээр улирал); - ХХБ-ны ТУЗ-ийн харьяа нэгжүүдийн ажилтнуудын чадамжийн үнэлгээний журамд нэмэлт өөрчлөлт оруулах тухай - ХХБ хувьцааг нь эзэмшдэг компанийн хувьцаа эзэмшигчдийн хуралд Банкныг төлөөлөн оролцох этгээдийг томилох тухай
2	Аудитын хорооны хурал	2025-02-10	цахимаар	ДАГ-ын 2024 оны ажлын тайлангийн танилцуулга“ДАГ-ын 2025 оны аудитын ажлын төлөвлөгөөний төслийн танилцуулга
3	ТУЗ-н хурал	2025-02-13	Цахимаар	- ХХБ-ны 2024 оны үйл ажиллагааны тайлан, санхүүгийн төсвийн гүйцэтгэл; - Ногдол ашиг хуваарилах тухай; - ДАГ-ын 2024 оны төлөвлөгөөний гүйцэтгэл, 2025 оны төлөвлөгөөний тухай.
4	ТУЗ-н тогтоолын төсөлд санал өгөх	2025-02-24	Саналын хуудсаар	- Хаалттай хүрээнд өрийн бичиг гаргах тухай - Си жи эф ХХК-ийн энгийн хувьцаа худалдан авах тухай - ХХБ хувьцааг нь эзэмшдэг компаниудын ХЭХХ-д банкныг төлөөлөн оролцох этгээдийг томилох тухай
5	ТУЗ-н хурал	2025-03-13	Цахимаар	Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал зарлан хуралдуулах тухай;

6	ТУЗ-н хурал	2025-03-26	Цахимаар	Худалдаа, хөгжлийн банкны 2024.12.31-ний өдрий байдлаарх тайланд хийсэн аудитын дүгнэлтийг танилцуулах, аудитын тайланг хүлээн авах тухай.
7	ТУЗ-н ээлжит бус хурал	2025.04.10	Цахим	- Банкийг тогтворжуулах төлөвлөгөө 2025-ыг батлах тухай - Мөнгө угаах терроризмыг санхүүжүүлэх болон үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэхийг санхүүжүүлэхтэй тэмцэх үйл ажиллагааны тайлан - ХХБ-ны холбогдох этгээдийн мэдээллийн сангийн журмыг батлуулах тухай
8	ТУЗ-н тогтоолын төсөлд санал өгөх	2025.04.15	Саналын хуудсаар	Худалдаа, хөгжлийн банк ХК-ийн 2024 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн удирдах зөвлөлийн гаргасан дүгнэлтийг хэлэлцэн батлах тухай
9	ТУЗ-н тогтоолын төсөлд санал өгөх	2025.04.23	Саналын хуудсаар	- Хөрөнгө худалдан борлуулахтай холбоотой эрх олгох тухай /Макс молл худалдааны төв/; - Хөрөнгө худалдан борлуулахтай холбоотой эрх олгох тухай /Монгол Түлхүүр ХХК/.
10	ТУЗ-н ээлжит бус хурал	2025 04 24	цахим	- Ногдол ашиг хуваарилах тухай. - Худалдаа хөгжлийн банкны 2025 оны өөрийн хөрөнгийн хүрэлцээний дотоод үнэлгээний тайлан (ICAAP) болон хөрвөх чадварын хүрэлцээний дотоод үнэлгээний тайлан (ILAAP) болон хураангуй тайлан болох CAS, LAS тайланг ТУЗ-өөр батлуулах тухай
11	Аудитын хороо, Эрсдэлийн удирдлагын хорооны хамтарсан хурал	2025 04 09	цахим	- Худалдаа хөгжлийн банкны 2025 оны Тогтворжуулах төлөвлөгөөг хэлэлцэх тухай, “Тогтворжуулах төлөвлөгөө 2025”-д хийсэн аудитын дүгнэлт
12	Аудитын хороо	2025 05 19	цахим	Зөвлөх үйлчилгээ авах зөвшөөрөл хүсэх тухай,
13	ЭУХороо	2025 04 25	цахим	- ХХБ-ны эрсдэлийн аппетитын 1-р улирлын гүйцэтгэл - ХХБ-ны өөрийн хөрөнгийн хүрэлцээний дотоод үнэлгээний тайлан болон хөрвөх чадварын хүрэлцээний дотоод үнэлгээний тайлан

Тэмдэглэл:

Тухайн улиралд хуралд оролцохдоо дараах чиглэлээр асуулт асуух, санал, зөвлөмж хэлэх, үүрэг даалгавар өгөх байдлаар ажиллалаа. Үүнд:

- ДАГ-ын үйл ажиллагааны төлөвлөгөө биелэлт, цаашид хэрэгжүүлэх арга хэмжээний талаар;

- 2025 оны ДАГ-ын үйл ажиллагааны төлөвлөгөөний талаар;
- Банкны үйл ажиллагаа, санхүүгийн үр дүнгийн талаар;
- Хувьцаа эзэмшигчдийн хурал, ногдол ашгийн бодлогын хүрээнд;
- Хөрөнгө худалдан борлуулах үйл ажиллагаатай холбоотой банкинд учирч болзошгүй алдагдал, үр ашигтай байх хувилбарын талаар;
- Банкыг тогтворжуулах төлөвлөгөөний боловсруулалт, тохиолдох магадлал, хариу үйлдэл үзүүлэх чадварын хүрээнд;
- Банкны эрсдэлийн удирдлага, аппетитын тооцоолол, хэрэгжилтийн талаар;
- Банкны үйл ажиллагаа, санхүүгийн тайланд ТУЗ-ийн зүгээс өгөх дүгнэлтийн талаар;

Бусад үйл ажиллагаа.

Тухайн улиралд аудитын хорооны даргын хувиар 2024 оны аудитын үйл ажиллагааны үр дүнд үнэлэлт дүгнэлт өгөх. 2025 онд ДАГ-ын үйл ажиллагааг улам сайжруулах тал дээр хорооны гишүүдийн хамт санал зөвлөмж өгөх талд илүү анхаарал хандуулж ажиллалаа. Үүнээс гадна ТУЗ-ийн үүргийн биелэлт, банкны үйл ажиллагаа, санхүүгийн нөхцөл байдлын үнэлгээ, гүйцэтгэх удирдлагын үнэлгээ зэрэгтэй холбоотой журмуудад санал өгөх, үнэлгээ хийх, банкны зохистой засаглалын зарчмын хэрэгжилтийн хяналт, шалгалтын журам, гүйцэтгэх удирдлагын I улирлын тайлан зэрэгтэй танилцах, санал өгөх ажлуудыг хийлээ.

ТУЗ, Эрсдэлийн удирдлагын хорооны гишүүн, Аудитын хорооны даргаар ажиллахдаа Компанийн хууль, Банкны тухай хууль, МБ-ны журам, ХХБ-ны дүрмийг мөрдлөг болгон банкны үйл ажиллагаатай холбоотой ТУЗ, Гүйцэтгэх Удирдлагын үйл ажиллагаа, гаргасан шийдвэр нь банкны эрх ашигт сөргөөр нөлөөлөх эсэх, хууль тогтоомжид нийцсэн эсэхэд хяналт тавих, банкны харилцагч, хадгаламж эзэмшигчийн эрх ашгийг хамгаалах зэрэг ТУЗ-ийн хараат бус гишүүний хувьд хүлээх нэмэлт үүрэг хариуцлагыг хэрэгжүүлэн ажиллахыг удирдлага болгосон болно.

Худалдаа Хөгжлийн Банкны

ТУЗ-ийн хараат бус гишүүн:



Ж.Дэлгэрсайхан

2025 оны 07 сарын 08

ХУДАЛДАА ХӨГЖЛИЙН БАНК
ТУЗ-ИЙН ХАРААТ БУС ГИШҮҮН Ж.БОЛОРМААГИЙН
2025 ОНЫ ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН ТАЙЛАН

Миний бие Төлөөлөн удирдах зөвлөл /ТУЗ/-ийн хараат бус гишүүн, ТУЗ-ийн дэргэдэх Цалин урамшуулал, нэр дэвшүүлэх хорооны дарга, Аудитын хорооны гишүүнээр өнгөрсөн хугацаанд ажиллалаа.

Тайлант хугацаанд Төлөөлөн удирдах зөвлөл, ЦУНДХ, АХорооны ээлжит болон ээлжит бус хурлуудад цахимаар, бичгээр санал өгөх аргаар оролцож, холбогдох асуудалд саналаа өгч ажилласан.

1. Төлөөлөн удирдах зөвлөлийн хурал дараах хугацаанд хуралдав.

- 1.1. 2025.01.17-ны өдөр;
- 1.2. 2025.02.13-ны өдөр;
- 1.3. 2025.02.24-ний өдөр;
- 1.4. 2025.03.13-ны өдөр;
- 1.5. 2025.03.26-ны өдөр;
- 1.6. 2025.04.10-ны өдөр;
- 1.7. 2025.04.15-ны өдөр;
- 1.8. 2025.04.23-ны өдөр;
- 1.9. 2025.04.24-ний өдөр;

Дээрх хурлуудаар хэлэлцүүлж байгаа асуудлуудтай танилцаж, санал өгөхдөө Компанийн тухай хууль, Банкны тухай хууль, бусад хууль тогтоомжийг баримтлан, хараат бус гишүүний хувьд шийдвэр гаргалтад оролцсон бөгөөд дараах төрлийн шийдвэрүүдийг гаргасан. Үүнд:

1. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг зарлан хуралдуулах;
2. Банкны засаглалтай холбоотой бодлого, журам, зааврыг хэлэлцэн батлах;
3. Банкны орлого, зардлын болон хөрөнгө оруулалтын төсөв, төлөвлөгөө батлах, өөрчлөлт оруулах, түүнд хяналт тавьж, улирал, жилийн гүйцэтгэлтэй танилцах, үнэлгээ дүгнэлт гаргах;
4. Худалдаа, хөгжлийн банкны эд хөрөнгийн болон эд хөрөнгийн эрхийн зах зээлийн үнийг тогтоох, худалдан борлуулах зөвшөөрөл өгөх;
5. ДАГ-ын 2024 оны төлөвлөгөөний гүйцэтгэл, 2025 оны төлөвлөгөөний тухай;
6. Банкны 2024 оны аудитлагдсан тайланг хүлээн авах;
7. Сонирхлын зөрчилтэй хэлцлийг зөвшөөрөх эсэх хүсэлийг шийдвэрлэх;
8. Банкны мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх болон үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэхийг санхүүжүүлэхтэй тэмцэх үйл ажиллагааны тайлан;
9. Ногдол ашиг хуваарилах;
10. Банк хувьцааг нь эзэмшдэг компанийн хувьцаа эзэмшигчдийн хуралд Банкийг төлөөлөн оролцох этгээдийг томилох тухай;
11. ТУЗ-ийн харьяа нэгжүүдийн ажилтнуудын чадамжийн үнэлгээний журамд нэмэлт өөрчлөлт оруулах тухай
12. ТУЗ-ийн эрхийн хүрээнд шийдвэрлэх бусад асуудал.

Тайлант хугацаанд ЦУНДХороо нь нийт 3 удаа хуралдаж, ТУЗ-өөс Банкны 2024 оны жилийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайланд өгөх үнэлгээний асуулга болон хувийн жинг батлах, ТУЗ-ийн гишүүнд нэр дэвшүүлэх, ГЗТО-ын гэрээг дүгнэх, сунгах зэрэг асуудлыг хэлэлцэж шийдвэрлэсэн байна. АХ-ны 3 удаагийн хурлаар ДАГ-ын жилийн тайлан, төлөвлөгөө, Банкны 2025 оны тогтворжуулах төлөвлөгөө, түүнд хийсэн аудитын дүгнэлтийг хэлэлцсэн.

Дээрх гарсан шийдвэрүүдэд зарчмын зөрүүтэй санал байгаагүй бөгөөд Хууль тогтоомжид нийцсэн шийдвэр гаргахад анхаарч, өөрийн саналаа өгч ажилласан.

Сонирхлын зөрчилтэй хэлцэл:

Тайлант хугацаанд буюу 2025 оны эхний хагас жилд сонирхлын зөрчилтэй хэлцлийн тухай асуудал ТУЗ-ийн хурлаар хэлэлцээгүй болно.

Компанийн тухай хууль, Банкны тухай хууль, Банкны дүрэм, ТУЗ-ийн үйл ажиллагааны журамд заасан гишүүний эрх, чиг үүргийн хүрээнд тайлант хугацаанд аливаа зөрчил, дутагдлыг арилгах, хяналт тавих хүрээнд тавьсан шаардлага байгаагүй ба хэлэлцсэн асуудлаар тавьсан саналыг ТУЗДАА болон Банкны удирдлага, газар нэгжээс хүлээн авч тухай бүр засаж залруулж, хэрэгжүүлж явсан бөгөөд ТУЗ-ийн хараат бус гишүүний хувьд хүлээх нэмэлт үүрэг хариуцлагыг хэрэгжүүлэн ажиллахыг удирдлага болгосон болно.

ТУЗ-ийн хараат бус гишүүн:

Ж.Болормаа